

## АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

**I. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 3807.8 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 3.2 дахин давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 1982.2 сая төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 12.2 хувиар давж биелсэн боловч Баруун-Урт суманд 17.6 хувиар тасарсан байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 1241.7 сая төгрөг болж, төлөвлөгдсөн хэмжээнээс 54.8 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Үүнд: Дарьганга 6.9 хувь, Баруун-Урт 8.5 хувь, Түмэнцогт 8.9 хувиар тус тус хэтэрсэн гүйцэтгэлтэй байна.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 12.2 тэрбум төгрөгт хүрсэн нь 2009 оны жилийн эцсээс 775 сая төгрөгөөр буурсан байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 10.2 тэрбум төгрөг болсон нь 2009 оны жилийн эцсээс 2.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөн банкуудын хугацаа хэтэрсэн зээл 0.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 53.8 хувь болох 416.1 мянган эх мал төллөж, гарсан төлийн 98.0 хувь болох 410.8 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр гүйцэтгэлтэй байна. Мөнххаан суманд 1 гүү, 2 үнээ ихэрлэж, Эрдэнэцагаан суманд 1 хонь 4 ихэр хурга гаргажээ.

Оны эхний малын 1.1 хувь болох 19.8 мянган мал зүй бусаар хорогдсон нь урьд оны мөн үеэс 4.5 дахин олон байна.

Түмэнцогт суманд оны эхний малын 7.6 хувь нь зүй бусаар хорогдоод байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж, МИДаатгалд хамрагдсан малчид нөхөн төлбөр авах болж байна.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 10.3 тэрбум төгрөг болсон нь урьд оны мөн үеийнхээс 0.5 тэрбум төгрөгөөр доогуур байна.

Оны үнээр 45.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 5.2 дахин дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Цайрын баяжмалын үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс 1.6 мян.тн-оор доогуур байна. Бусад нэр төрөл дээгүүр гүйцэтгэлтэй байна.

**VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний үнийн индекс 4-р сард 2009 оны жилийн эцсийнхээс 7.3 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 15.3 хувиар, түүн дотроо хүнсний бараа 15.8 хувь, үүнээс мах махан бүтээгдэхүүний үнэ 56.1 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 18.0 хувь, жимс, жимсгэнэ 28 хувь, хүнсний ногоо 41.3 хувиар тус тус өссөн байна.

Тээврээс бусад бүлгийн үнэ өссөний дотор гэр ахуйн бараа-ны бүлгийн үнэ 0.9 хувь, орон сууц, цахилгаан, хийн болон бусад түлшний тариф 1.0 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ 1.1 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний тариф 1.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний үнэ тариф 2.3 хувь, холбооны тариф 31.3 хувиар тус тус өсч, боловсрол, нийтийн хоол, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний үнэ, тариф тогтвортой байлаа.

**VIII. ЭРҮҮЛ МЭНД:** 385 эх амаржсан байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 12 болж урьд оны мөн үеэс 8-аар олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 184 болж, урьд оны мөн үеэс 99-өөр доогуур байна. Вируст гепатит, салхинцэцэг, тэмбүү, заг, трихоминиаз зэрэг өвчнүүд буурсан байна.

**IX. АЖИЛГҮЙЧҮҮД:** Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1157 болж, урьд оны мөн үеийнхээс 53 хүнээр нэмэгдсэн байна. Ажилгүйчүүдийн 66.7 хувь нь 16-34 насны залуучууд, 17.8 хувь нь дээд, 4.7 хувь нь тусгай дунд, 37.3 хувь нь бүрэн дунд, 7.6 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

488 хүн шинээр бүртгүүлж, 352 хүн ажилд орсон байна.

Шинэ ажлын байранд ажиллаж байгаа хүний тоо 122-т хүрчээ.

**X. ГЭМТ ХЭРЭГ:** 56 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 12-аар доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 11 хүн нас барж, 13 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 18.6 сая төгрөгийн хохирол учирсны 16.8 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 54 хүн холбогдон сэжиглэгдсэний 16.7 хувь нь согтуугаар, 14.8 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 829 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 15 хүнээр дээгүүр байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 48 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Хэрэг илрүүлэлт 93.1 хувьтай байна.

**XI. МАЛЫН ИНДЕСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ:** 2010 онд Сүхбаатар аймагт МИД төслийг хэрэгжүүлэх эрх авч Монгол даатгал, Практикал даатгал, Прайм даатгал, Бодь даатгал гэсэн 4 даатгалын компаниуд ажиллаж байна.

2010 оны 05 сарын 03-ны байдлаар 4 сумын 29 өрхийн 11.5 мянган толгой малыг 4.5 сая төгрөгөөр даатгалд хамруулсан байна.